



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 7 сарын 01 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

XXII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 15:00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлагын танхим”-д 76 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ, вирусн мутацилагдсан хувилбарын талаар

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

2. Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар,

3. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт өндөр байгаатай холбогдуулан эрүүл мэнд, тагнуул, мэргэжлийн хяналт, онцгой байдал, цагдаа, хил, гаалийн байгууллага болон коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд ажиллаж байгаа байгууллагаас бусад төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 9-ний өдрийг дуустал 10 хувиар ажиллуулж, бусад албан хаагчдыг ажил үүргээ зайнаас гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлж халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн нарт:

2.1. Монгол-Оросын хилийн авто замын “Алтанбулаг” боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл түр зогсоох тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

Гурав. Улсын онцгой комиссын гишүүд, Үндэсний Их баяр наадам зохион байгуулах хорооны дарга, Нийслэлийн Засаг дарга нарт:

3.1. Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил Ардын хувьсгалын 100 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг хойшлуулах зэрэг коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, Засгийн газрын хуралдаанд санал танилцуулж шийдвэрлүүлэх;


Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддорж нарт:


4.1. Тавантолгойн бүлэг ордын аюулгүйн тусгай бүсийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, Цагаан хадны гаалийн хяналтын бүсийг “Ногоон бүс” болгож, коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулж, нүүрсний тээвэрлэлтийн тасралтгүй байдлыг хангах, халдвар хамгааллын дэглэм, хэв журмыг сахиулах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, уг ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Тавантолгойн бүлэг ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлэх;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт:

5.1. SARS-CoV-2 вирусын анхаарал татсан "Дельта" хувилбар /B.1.617.2/ голомтлон тархах эрсдэлээс сэргийлж 2021 оны 7 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн гадаад улсаас вакцины бүрэн тунд хамрагдан ирж буй зорчигч бүрийг 14 хоног гэрийн ажиглалтад шилжүүлэх;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ОРЛОГЧ ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ  Г.АРИУНБУЯН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т.БАЯРХҮҮ